



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 4 дугаар
сарын 29 өдөр

Дугаар 6.64

Улаанбаатар
хот

"Өргөө зочид буудал" компанийн дүрэм батлах тухай

1. "Өргөө зочид буудал" компанийн дүрмийг хэвсралт ёсоор баталсугай.

2. "Өргөө зочид буудал" компанийн зохион байгуулалт, орон тооны байдалд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллахыг Нийтлэг үйлчилгээний газар (н.Дашням)-т даалгасугай.

3. "Өргөө зочид буудал" компанийн үйл ажиллагаа явуулахад хөрөнгийн эх үүсвэргүй байгааг харгалзан эргэж төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулж зохих хөрөнгийн дэмжлэг үзүүлэхийг Нийтлэг үйлчилгээний газар (н.Дашням), Өмчийн газар (н.Буянмөнх)-т зөвшөөрсүгэй.

4. Энэ захирамж гарсантай холбогдон Нийслэлийн Засаг даргын 1995 оны А/145 тоот захирамжийн 1 дүгээр заалтыг хүчингүй болсонд тооцсугай.



М.ЭНХБОЛД

87
Нийслэлийн засаг даргын 1999 оны
...захирамжийн хавсралт

"Өргөө зочид буудал" /УҮГ/ компанийн дүрэм.

Нэг.Нийтлэг үндэслэл.

1.Хуулийн этгээд болох "Өргөө зочид буудал" /УҮГ/ компани нь зашид компани гэнэ/ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын Тамгын газар, Нийслэл дүүргүүдийн төр захиргааны бусад байгууллагуудын шугамаар ирэх зочин төлөөлөгчдийг хүлээн авах, буудлаар үйлчлэх худалдаа үйлчилгээ болон бусад аж ахуйн чанартай үйл ажиллагаа явуулан аж ахуйн тооцоон дээр бие дааж үйлдвэрлэл үйлчилгээ явуулж Монгол улсын зохих хуулийн дагуу төрийн өмчид үндэслэгдэж байгуулагдсан компани /УҮГ/ хэлбэрээр ажиллана.

2. Компаний оноосон нэр нь "Өргөө зочид буудал" бөгөөд төв нь Улаанбаатар хотод байрлана.

3. "Өргөө зочид буудал" компани нь Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1- дүгээр хорооны нутаг дэвсгэрт М-100-р байр, 6-р орцонд байрлана.
Утас 313726, факс 976-1-312712

4. Компани нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие дааж иргэний гүйлгээнд ордог. Хуулийн этгээд мөн.

5. Компанийн дүрмийн сан	172,6 сая.төгрөг
а. Үндсэн хөрөнгө	156,7 сая.төгрөг
б. Эргэлтийн хөрөнгө	42,7 сая.төгрөг

Хоёр. Компаний үйл ажиллагааны эрх, хэмжээ

1. Компанийг байгуулах тухай шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд тооцож, нөхөрлөл,компанийн хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

2.Компани нь өөрийн нэрийн өмнөөс гадаад дотоодын байгууллагуудтай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгийн ба эд хөрөнгийн бус эрх адлэх,үүрэг хүлээх түүнчлэн шүүх, арбитрайн байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцох эрхтэй.

3. Компани нь ажлын шаардлагаас шалтгаалан өөрийн харъяанд аж ахуйн нэгж, цэг салбар нээж ажиллуулах, татан буулгах, хуулийн дагуу харьяа салбар төлөөлөгчийн газартай байж болно.

4."Өргөө зочид буудал" /УҮГ/ компани нь өөрийн нэр бүхий тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж бие даасан данстай, тайлан тэнцэлтэй хуулийн этгээд байна.

5. Ашиглалт, засварын түүхий эд, материал, тоног төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.

6. Компани нь дараахь хөрөнгийн эрх, үүрэгтэй.

А. Өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглах.

Б. Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

В. Ажил үйлчилгээ явуулсны үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж захиран зарцуулах.

7. Компани нь дор дурьдсан үйл ажиллагааг явуулна.

А/ Компани нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, НИТХ, Засаг даргын шийдвэр болон энэхүү дүрмийг удирдлага болгон зочин төлөөлөгчдийг хүлээн авах, буудлаар үйлчлэх, хүмүүсийн амгалан тайван, тус тухтай байдлыг бүрэн хангаж, соёлч боловсон үйлчилгээг хэвшүүлэхэд ажлаа чиглүүлнэ.

Б/ Зочид буудлын үйлчилгээг эрхлэн явуулах

В/ Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, нийтийн хоолны үйлчилгээ явуулах

Г/ Гадаад, дотоод худалдаа эрхлэх

Д/ Хүнсний зарим бүтээгдэхүүнийхээ хэрэгцээг хангах зорилгоор туслах аж ахуй эрхлэх

Е/ Бусад төлбөртэй үйлчилгээ явуулах

Гурав. Компанийг үүсгэн байгуулагчийн эрх.

1. Компанийг үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байна.

2. Компаний захирлыг Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч томилон ажлаас чөлөөлнө.

Дөрөв. Компанийн захирлын эрх хэмжээ.

1. Компанийн захирал нь үйл ажиллагаагаа гүйцэтгэн явуулахад 3-5 хүний бүрэлдэхүүнтэй захирлын зөвлөлтэй байж болно.

2. Тухайн асуудлыг шийдэхдээ зөвлөлийн олонхийн саналыг харгалзаж захирал шийдвэр гаргана.

3. Компанийн эдийн засаг, бизнесийн төлөвлөгөөг Нийслэлийн засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газартай зөвшилцөн хянуулж батлуулна..

4. Компанийн орон тоо, зохион байгуулалтын бүтэц, ажиллагсадын цалингийн хэмжээ, урамшлын журмыг Нийтлэг үйлчилгээний газартай зөвшилцөн тогтооно.

5. Захирлын зөвлөлийн хурал 7-14 хоногт нэгээс доошгүй удаа хуралдана.

6. Компанийн хэмжээнд мөрдөж ажиллах байгууллагын дотоод журмыг зөвлөлөөр хэлэлцэж захирлын тушаалаар батлана.

7. Захирал нь ажилтныг ажилд авах, чөлөөлөх, сахилгын арга хэмжээ авах, тэдний цалинг тогтоох зэргийг зөвлөлөөр шийдэж болно.

Тав. Компаний захирал түүний үүрэг.

1. Захирал нь энэ дүрэм болон гэрээнд заасан хугацаанд тогтоож өгсөн эрх хэмжээний дотор компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

2. Захирал нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өмнө ажлаа тайлагнана.

3. Компанийг гадаад, дотоод бүрэн эрхтэйгээр төлөөлөх, бусдад итгэмжлэл олгох.

4. Компанийн нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах.

5. Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулах.

6. Маргаантай асуудлаар компаниа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гарах ба хууль хяналтын байгууллагад хандах.

7. Эрх хэмжээнийхээ хүрээнд компанийхаа хүрээнд дагаж мөрдөх тушаал гаргах.

8. Монгол улсын холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг хүлээнэ.

Зургаа. Санхүү, бүртгэл.

1. Санхүү бүртгэлийн сиситем нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, түүнд орсон өөрчлөлтийн дагуу явагдана.

2. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

3. Компани нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

4. Компани нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5. Компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

6. Компанийн тооцоо, тайлангийн дүнг төгрөгөөр илэрхийлнэ.

Долоо. Санхүүгийн хяналт.

1. Компанийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, эзэмшилт, ашиглалт, захиран зарцуулалтад эрх бүхий байгууллагууд ерөнхий хяналт шалгалтыг холбогдох хуулийн дагуу хэрэгжүүлнэ.

2. Компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Найм. Татан буулгах.

1. Компанийг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагч хуульд заасан үндэслэлээр гаргана.

Ес. Бусад асуудал

1. Энэхүү дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

2. Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Монгол улсын бүртгэлийн болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.